



“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал”
ТӨХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн 01 дугаар албан бичгийн хавсралт

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.12.12

Улаанбаатар хот

Д/д	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хувь
1.	4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	<p>Компанийн эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, зохион байгуулалтын бүтэц, компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, цаг үеийн мэдээ мэдээлэл, ажлын байрны сонгон шалгаруулалтыг http://khkhar.mn цахим хуудаст байршуулж, иргэд олон нийт танилцах боломжоор бүрэн хангасан. Мөн компанийн 2020, 2021, 2022 онд хэрэгжүүлсэн ажлын товч танилцуулгыг http://www.khkhar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтэд ил тод нээлттэй болгосон.</p> <p>“Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”, “Авлигын индексийг буурах ажлын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллав.</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаатай холбогдуулан компанийн ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, уг гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөх, авлига авах, түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар тусгайлсан заалтыг орууллаа.</p> <p>Монгол улсын Авлигатай тэмцэх газрын цахим хуудас (https://www.iaac.mn)-т гарсан мэдээ мэдээллийг компанийн нийт ажилтнуудад тухай бүр тогтмол танилцуулж, Авлигатай тэмцэх газрын цахим хуудсыг компанийн http://www.khkhar.mn цахим хуудасны авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл цэстэй холбож, иргэд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор тус мэдээллийн самбарын дагуу гомдол, мэдээлэл ирээгүй болно.</p>	100

			<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон мөрдөгдөж буй дүрэм, журам, стандартын дагуу Санхүү бүртгэлийн Impact, Цалингийн Payroll программуудыг ашиглан бүртгэл тооцоог хөтлөн явуулж байна.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Компанийн санхүүгийн тайлан мэдээллийг компанийн болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулан, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн tender.gov.mn, shilendans.gov.mn цахим хуудсаар иргэд, олон нийтэд мэдээлэв.</p> <p>Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 154 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулж хуулийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаа.</p> <p>Компанийн бүтэц, зохион байгуулалт 1, ажлын байрны сонгон шалгаруулалтын 4, цаг үеийн мэдээ, мэдээллийг 67 удаа http://www.khkhap.mn цахим хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Олон нийтийн facebook цахим сүлжээнд "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" хаяг нээж, компанийн үйл ажиллагаатай холбоотой 110 мэдээ, мэдээллийг байршууллаа.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааг хангах зорилгоор 27 гэрээг 12 аж ахуйн нэгж, байгууллага, 4 иргэнтэй хийж ажилласан ба бүрэн хэрэгжсэн 5, хүчинтэй хугацаандаа хэрэгжиж байгаа 22 гэрээ байгаа бөгөөд гэрээ байгуулахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөх, авлигаас урьдчилан сэргийлэх талаар анхааруулж ажиллав.</p>	
--	--	--	---	--

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС 2022 ОНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

д/д	Ирүүлсэн зөвлөмж	Биелэлт	Хувь
1.	<p>ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаанд доорх зөвлөмжийг баримталж ажиллах.</p> <p>Авлигатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн цахим шуудан</p>	<p>Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “ХАСХОМ-ийн 2021 оны тайлан” нь https://meduuleg.iaас.mn цахим системд бөглөж, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 91 дүгээр тушаалын 1, 2 хавсралтуудаар батлагдсан мэдээ тайланг уг цахим системээс PDF файлаар хөрвүүлж гаргав.</p> <p>Компанийн 6 удирдах ажилтны 2021 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн дагуу 1 сарын дотор мэдүүлэх ажлыг зохион байгуулж, Эрх бүхий албан тушаалтны баталгаажилтыг хийв.</p> <p>Компанийн ажлын сул байранд шинээр томилогдох 1 эрх бүхий ажилтны нийтийн албанд ажиллах ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хариуг үндэслэн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилов.</p> <p>Мэдүүлэг гаргагч нарт зориулсан видео сурталчилгааг өөрийн байгууллагын вэб хуудас болон сошиал хуудсанд тус тус байршуулж, мэдүүлгийг бодитой, шуурхай мэдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05/13472 тоот албан бичгээр ирүүлсэн “2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг хангах тухай”, 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн цахим шуудангаар ирүүлсэн “ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаанд доорх зөвлөмжийг баримталж ажиллах” зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/43 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнасан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн цахим системийн шинэчлэл" цахим сургалтад Захиргааны хэлтсийн дарга Р.Бат-Оргил оролцож, сургалтаас өгсөн мэдээллийг ХАСХОМ гаргах эрх бүхий ажилтнуудад танилцуулав.</p>	100

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ АВЛИГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
1	<p>Авлигад өртөх магадлал бүхий албан тушаалын жагсаалтыг албан хаагчдын дунд судалгаа явуулж тодорхойлон, зөвлөмж зөвлөгөө боловсруулж тухайн албан тушаалтнуудад хүргүүлэх;</p>	<p>Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны ХЭХТ19/03 тогтоолоор батлагдсан “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн бүтэц, орон тоог Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ХЭХТ21/05 дугаар тогтоолоор 41 ажилтантай байхаар шинэчлэн баталж, одоогоор 28 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Эдгээрээс Гүйцэтгэх захирал, Захиргааны хэлтэс, Нисэх буудлын үйлчилгээний хэлтэс, Санхүү-төлөвлөлт, хяналтын хэлтсийн дарга болон ерөнхий нягтлан бодогч зэрэг 5 ажилтан авлигад өртөх магадлал бүхий албан тушаалд ажиллаж байна.</p> <p>Эрх бүхий албан тушаалтнуудад мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмж өгөх, мэдээлэл солилцох зорилго бүхий “Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл” нэртэй facebook хуудаст тавигдсан мэдээлэл, зөвлөмжийг компанийн нийт ажилтнуудад тухай бүр тогтмол танилцуулж, Авлигатай тэмцэх газраас гаргасан зөвлөмж, журмыг компанийн мэдээллийн самбарт байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаатай холбогдуулан компанийн ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээг байгуулж, уг гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөх, авлига авах, түүнд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар тусгайлсан заалтыг орууллаа.</p>	100
2	<p>Зам, тээврийн салбарын хэмжээнд худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулан, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулж байх;</p>	<p>Компанийн эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, зохион байгуулалтын бүтэц, компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, цаг үеийн мэдээ мэдээлэл, ажлын байрны сонгон шалгаруулалтыг http://khkhar.mn цахим хуудаст байршуулж, иргэд олон нийт танилцах боломжоор бүрэн хангасан.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Компанийн санхүүгийн тайлан мэдээллийг компанийн болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулан, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн tender.gov.mn, shilendans.gov.mn цахим хуудсаар иргэд, олон нийтэд мэдээлж, Шилэн дансанд 2022 оны 12 дугаар сар хүртэл нийт 154 мэдээллийг оруулсан.</p> <p>Мөн Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн 2022 оны ерөнхий мэдээллийг сар бүрийн 5-ны өдөр буюу 11 удаа хуулийн хугацаанд нийтэд мэдээлсэн.</p>	100

3	Зам, тээврийн салбараас олгож буй тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн ажлыг цахим хэлбэрт шилжүүлж, олон нийтэд ил тод байлгаж, мэдээлэл авах боломж бүрдүүлэх;	Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй болно.	-
4	Зам, тээврийн салбарын хэмжээнд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;	<p>Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2020 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөс 2021 оны 2 дугаар сараас хойших хугацаанд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах чиг үүргийг хэрэгжүүлэхээр томилогдсон эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан цахим сургалтын мэдээлэл, материалтай компанийн эрх бүхий албан тушаалтан танилцсан.</p> <p>Улсын хэмжээнд ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулахтай холбоотой бэлтгэлийг хангуулах зорилгоор мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан цахим сургалтад 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр эрх бүхий ажилтныг хамруулсан.</p> <p>Сургалтын холбогдох мэдээлэл, материалыг ашиглан ХАСХОМ мэдүүлэх эрх бүхий ажилтнуудад цахим сургалт явуулж, 6 ажилтны 2021 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн дагуу 1 сарын дотор мэдүүлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>Авлигатай тэмцэх газраас 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан "Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн цахим системийн шинэчлэл" цахим сургалтад Захиргааны хэлтсийн дарга Р.Бат-Оргил оролцож, сургалтаас өгсөн мэдээллийг ХАСХОМ гаргах эрх бүхий ажилтнуудад танилцуулав.</p>	100
5	ЗТХЯ-ны харьяа байгууллагын ажлыг үнэлэхдээ авлигын индекс бууруулах талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцох.	<p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2021 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр 97.8 хувьтай дүгнэгдсэн.</p> <p>Компанийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас авлигатай холбоотой санал, гомдол гараагүй болно.</p>	100